



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/17.

Хэрлэн сум

Нэр өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд заасны дагуу Хэнтий аймгийн Уламжлалт анагаах ухааны төвийн оноосон нэрийг **Уламжлалт анагаах ухаан болон хүүхдийн сэргээн засах төв** болгон өөрчилсүгэй.

2. Бичиг баримтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрдүүлж улсын бүртгэлд бүрдүүлэхийг Уламжлалт анагаах ухаан болон Хүүхдийн сэргээн засах төвийн дарга /М.Даваа/-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 1999 оны 01 дугаар сарын 22-ны 09 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

Н.ГАНБЯМБА